ТӨГС БҮСГҮЙЧҮҮД

Төрийн бус байгууллага

“ТӨГС БҮСГҮЙЧҮҮД” ТББ-ЫН ТАНИЛЦУУЛГА

Мэдээллийн багц-1

- 1998 оноос эхлэн ДОХ-той тэмцэх Үндэсний сангийн дэмжлэгтэйгээр “Итгэл” төслийг УБ хотын эрсдэлт бүлгийн олон нийтэд хэрэгжүүлж эхэлсэн.
- 2011 оноос “Төгс бүсгүйчүүд” ТББ болон ажиллаж байна.
- “Төгс бүсгүйчүүд” ТББ-ын удирдах зөвлөл 7 гишүүнтэй. Төсөл хэрэгжүүлэх баг нь гүйцэтгэх захирал, төслийн менежер, хяналт-шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн, их эмч, нягтлан бодогч, нийгмийн ажилтан, кейс менежер болон 12 хүрч очих ажилтантай, хамтран ажиллагч орон нутгийн дэд салбар хүлээн авагч 9 аймагт 31 хүн (1 аймагт төслийн менежер 1, хүрч очих ажилтан 2-4), нийт 51 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа хэрэгжүүлж байна.

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр

- 2004-2007 онд ДОХ-той тэмцэх үндэсний сангийн дэмжлэгтэй “ЭБҮ-дийн хөтөлбөр”
- 2007-2011 онд Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төсөл
- 2011-2014 онд Глобаль сангийн дэмжлэгтэй Нэг урсгалт санхүүжилттэй ДОХ-ын нэгтгэсэн төсөл
- 2015-2017 онд ХДХВ, ДОХ-оос сэргийлэх тусламж үйлчилгээ, дэмжлэгийн үндэсний хөтөлбөрийг өргөжүүлэх замаар ХДХВ, БЗДХ-ын тархалтын бага түвшинг тогтоон барих төсөл

ЗОРИЛГО

Эрсдэлт бүлгийн хүн ам болох ЭБҮ-ийн дунд ХДХВ, БЗДХ-аас сэргийлэх, тусламж үйлчилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр тэдний болон үйлчлүүлэгчдийн дундах ХДХВ, БЗДХ-ын тархалтыг бууруулах

Чиглэл

- ХДХВ, БЗДХ-аас сэргийлэх мэдлэг, мэдээлэл олгох, зан үйл өөрчлөх
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх
- Ээлтэй орчинг бий болгох, хамтрагч талуудын оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн ухуулга, нөлөөллийн үйл ажиллагаа
- Төр болон ТББ-ын хамтын ажиллагааг бэхжүүлэх, чадавхжуулах, хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт, үнэлгээ хийх

Үйл ажиллагааны чиглэл 1:

ХДХВ, БЗДХ-аас сэргийлэх мэдлэг, мэдээлэл олгох, зан үйл өөрчлөхөд чиглэсэн үйл ажиллагаа:

- Хүрч очих үйл ажиллагаа
- Ує тэнгийн сургагч бэлтгэх сургалт
- Нуугдмал олон нийтийг илрүүлэх
- Бүлгийн ярилцлага
- Идэвхжүүлэх үйл ажиллагаа
- Мэргэжил олгох сургалтанд хамруулах

Үйл ажиллагааны чиглэл 2:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх

- Төвөөр дамжуулан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх
- Явуулын сайн дурын зөвлөгөө шинжилгээ
- Ганцаарчилсан зөвлөгөө
- ЭБҮ-дийн үйлчлүүлэгч, хамтран амьдрагч нарыг эмчилгээ, үйлчилгээнд хамруулах



Үйл ажиллагааны чиглэл 3:

Ээлтэй орчинг бий болгох, хамтрагч талуудын оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн ухуулга, нөлөөллийн үйл ажиллагаа

- Цагдаагийн байгууллагын удирдах, шийдвэр гаргах түвшний ажилтнууд, албан хаагчид
- Хүчирхийллийн эсрэг үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын төлөөлөл
- Баар буудлын эздэд чиглэсэн ухуулга, нөлөөллийн уулзалт

Үйл ажиллагааны чиглэл 4:

Төр болон ТББ-ын хамтын ажиллагааг бэхжүүлэх, чадавхжуулах, хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт, үнэлгээ хийх

- УБ хот, орон нутгийн хүрч очих ажилтнууд
- ТББ-уудын менежер, нийгмийн ажилтан, эмч нар
- Кейс менежментийн сургалт
- Орон нутагт дэд салбар хүлээн авагч ТББ-уудын үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийх, арга зүйн дэмжлэг үзүүлэх
- УБ хотын хүрч очих үйл ажиллагаанд дотоодын хяналт үнэлгээ хийх, арга зүйн дэмжлэг үзүүлэх

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр

- ДОХ-той тэмцэх үндэсний сан
- Монголын Гэр бүл сайн сайхны нийгэмлэг
- ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА
- Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
- “Пакт” олон улсын байгууллага
- Монголын Улаан Загалмайн нийгэмлэг
- Хүйсийн Тэгш Эрхийн Төв
- Залуус эрүүл мэнд төв, “Хамтдаа” ТББ
- “Бутайн оргил” ТББ
- ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл
- НЭМГ “Сэтгэл амар” төвүүд
- Хүний хөгжил, НҮЭМ-Эрх ТББ-уудын сүлжээний гишүүн
- Ази Номхон Далайн Бүсийн ЭБҮ-дийн холбооны гишүүн байгууллага
- ЦЕГ-ын Нийтийн Хэв Журам Хамгаалах алба
- УБ хотын Цагдаагийн газар
- “Өөдрөг амьдрал” ТББ
- “Сэтгэл зүйн мэдрэмж” ТББ-уудтай хамтран ажиллаж байна.



- 2015-2017 онд “Төгс бүсгүйчүүд” ТББ нь ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн хүрээнд эрсдэлт бүлгийн хүн амд ХДХВ, ДОХ-оос сэргийлэх тусламж үйлчилгээ, дэмжлэгийн үндэсний хөтөлбөрийг өргөжүүлэх замаар ХДХВ-ын халдварын тархалтын бага түвшинг тогтоон барих төслийг Улаанбаатар хотын 6 дүүрэг болон орон нутгийн 9 аймагт амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Хамтран ажиллагч Дэд салбар хүлээн авагч байгууллагууд:
    - Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ”Чуулсан Үгс” ТББ
    - Дархан-Уул аймгийн “Эмэгтэйчүүдийн Итгэл Найдвар Холбоо” ТББ
    - Дорнод аймгийн “ЛЭОС” ТББ
    - Сэлэнгэ аймгийн “Хатан замнал” ТББ
    - Орхон аймгийн “Эрхэмсэг оршихуй Эрдэнэт” ТББ
    - Өмнөговь аймгийн “Говийн ухаан” ТББ
    - Баянхонгор аймгийн “Хонгорын төгс тэмүүлэл” ТББ
    - Ховд аймгийн “Түгээмэл орчлон” ТББ
    - Хөвсгөл аймгийн “Төгс зохицол-Гэр бүл” ТББ

ТӨГС БҮСГҮЙЧҮҮД

Төрийн бус байгууллага

БЗД 18-р хороо “Шинэ зуун” хотхон
24г-22 тоот
Улаанбаатар хот, Монгол улс

Утас:77055390
www.tugsbusguichuud.mn

ЭМЯ, Глобаль сангийн ДОХ, Сүрьеэгийн төслийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэвлүүлэв.